**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 04 өдөр          Дугаар А/05          Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1434 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хангай цогцолбор сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж, тохижилтын ажил (БХД, 1, 2 дугаар хороо) нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Б.Цогжавхлан | Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Э.Соёмбобат | Нийслэлийн Ерөнхий боловсролын Хангай цогцолбор сургуулийн захирал |
| | Ө.Амарзаяа | Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | Д.Даваасамбуу | 1 дүгээр хорооны иргэн |
| Нарийн бичиг | Д.Амгалан | Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн |

2.Хууль тогтоомжийн дагуу нийлүүлэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Б.Цогжавхлан)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА          А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200007